

© “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2019

## 2020 ОНД НЭГ САЯ ЖУУЛЧИН ХҮЛЭЭН АВАХ БОЛОМЖ БУЮУ ТАВАН БОГД ГРУППИЙН “20.1 САЯ” ХӨТӨЛБӨР

Ц.Баатарсайхан<sup>1</sup>

Аялал жуулчлал нь Монгол Улсад төвлөрүүлдэг орлогын хэмжээгээр нүүрс, зэсийн дараа гуравт жагсдаг, эдийн засгийн хувьд чухал ач холбогдолтой салбар юм. Тиймээс Монгол Улсын Засгийн газраас аялал жуулчлалыг эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгон хөгжүүлэх зорилго тавин, энэ чиглэлийн хөтөлбөр, санаачлагыг дэмжин ажиллаж байна. Иймд Таван богд группээс санаачилсан 2020 онд нэг сая жуулчин хүлээн авах боломж буюу “20.1 сая” хөтөлбөрийг Та бүхний анхааралд толилуулж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор Байгаль орчин, аялал жуулчлалын яам тус салбарыг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, хэрэгжүүлэх шаардлагатай хөтөлбөрийн талаар “Түүхэн аялал жуулчлал - Хөрөнгө оруулалт” үндэсний чуулганыг 2019 оны дөрөвдүгээр сарын 22-ны өдөр зохион байгууллаа.

Чуулганы үеэр Таван Богд Группийн Ерөнхийлөгч Ц.Баатарсайхан 2020 онд Монголд айлчлах гадаад жуулчдын тоог 1 саяд хүргэхэд манай улсын эдийн засагт гарах эерэг өөрчлөлтүүд, одоо байгаа боломж, гарц, шийдлийн талаар “20.1 сая” хөтөлбөрийн талаар сонирхолтой илтгэл тавьсан билээ (“569 сая ам.долларыг хэрхэн 1.1 тэрбум болгох вэ?”).<sup>2</sup>

### 1. Нэг сая жуулчин хүлээж авбал орлого хэрхэн өсөх вэ?

2019 онд аялал жуулчлалын орлого 754 сая долларт хүрэх төсөөллийг салбарын мэргэжилтнүүд гаргаад байна. Зөвхөн 2019 оны нэгдүгээр сарыг авч үзвэл, жуулчны тоо өмнөх оны мөн үеэс долоон хувь өссөн бол орлогын хэмжээ 11 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа юм.

Мөн энэ оны долоодугаар сараас Монгол, БНСУ-ын хооронд агаарын тээврийн салбарт чөлөөт өрсөлдөөн бий болж БНСУ-ын талаас хоёрдогч авиа компани болох Asiana Airlines Сөүл–Улаанбаатар чиглэлд нислэг үйлдэж эхэлнэ. Тус чиглэлд агаарын тээврийн чөлөөт өрсөлдөөн бий болсноор зорчигчдын урсгал 110000 хүртэл нэмэгдэх боломж бий болж байгааг Зам, тээврийн хөгжлийн сайд асан Я.Содбаатар хэлж байсан билээ.

<sup>1</sup> Таван богд группийн Ерөнхийлөгч. Цахим шуудан: [pr-manager@tavanbogd.com](mailto:pr-manager@tavanbogd.com)

<sup>2</sup> <http://ikon.mn/opinion/1k8e>

Тэгвэл 2019 онд Монгол Улсыг зорин ирэх жуулчдын тоо 700 мянгад хүрч энэ салбарын орлого 754 саяд хүрэх боломжтой. Улмаар 2020 он гэхэд жуулчдын тоо нэг саяд хүрвэл салбарын орлого хамгийн багадаа 1.1 тэрбум долларт хүрэх боломжтой юм.

Зураг 1

“20.1 сая” хөтөлбөрийн үр дүн



## 2. Аялал жуулчлал яагаад чухал вэ?

Дунджаар тухайн улсад ирж буй 30 жуулчин тутамд 1 ажлын байр бий болдог гэх судалгаа байдаг аж.

Зураг 2

Ажлын байр нэмэгдэх боломж



Эх сурвалж: www.nso.mn, www.wttc.org. Travel & Tourism Economic Impact 2018 Mongolia  
Монгол Улсын хувьд 2018 оны байдлаар тус салбараас 37 мянган хүн ажлын

байраар хангагдаж байгаа бол шууд бусаар 133 мянган хүний орлогод нөлөөлж байна. Тэгвэл 2020 онд бид **нэг сая жуулчин хүлээн авах зорилгодоо хүрвэл шууд ажлын байр 66 мянга болж шууд бусаар 225 мянган хүний амьжиргаанд нэмэлт орлого болж нөлөөлөх болно.**

Дэлхийн нийт ажиллах хүчний 10 хүн тутмын нэг нь аялал жуулчлалын салбарт харъяалагддаг. Сүүлийн таван жилийн хугацаанд дэлхий дахинд шинээр бий болсон таван ажлын байр тутмын нэг нь Аялал жуулчлалын салбарт бий болжээ.<sup>3</sup>

Өнөөдөр монголчуудын санааг зовоож буй хамгийн чухал асуудлын нэгд, амьжиргааны түвшин, хоёрт, ажилгүйдэл орж байна. Хамгийн сүүлийн байдлаар ажилгүй иргэдийн тоо 89000 байна.

Тэгвэл аялал жуулчлалын салбарыг хөгжүүлснээр салбар дахь шууд ажлын байрыг нэмэхээс гадна олон хүнийг орлогын нэмэлт эх үүсвэртэй болгох, мөн нийт худалдаа, үйлчилгээний бизнес эрхлэгчийн орлого нэмэгдэх эерэг нөлөөтэй билээ. Өөрөөр хэлбэл, иргэдийн шууд орлогод ач тус ихтэй учир улс орнууд аялал жуулчлалын салбараа бодлогоор дэмждэг байна.

### 3. Монгол Улсад ямар боломж байна вэ?

Манай оронд ирэх жуулчны тоог нэмэх маш их боломж байгааг дараах тоо баримт харуулж байна.

Зураг 3

#### Жуулчин татах боломж



Эх сурвалж: <https://www.e-unwto.org/doi/pdf/10.18111/9789284419876>

<sup>3</sup> www.wttc.org.

Зураг 3-аас харахад, 2018 онд Монгол Улстай шууд нислэг үйлддэг таван улсын гадагшаа аялсан иргэдийн тоо 341 саяд хүрээд байна. Эдгээр жуулчны ердөө 3.4 хувийг Монголд хүлээн авахад бидний НЭГ САЯ жуулчин хүлээн авах зорилго биелэгдэх юм.

Амадеус системийн судалгаагаар 2018 онд олон улсад давтагдсан тоогоор 114 сая удаа Монгол руу аялах талаар онлайн хайлт хийсэн байна. Үүний 21 сая нь БНСУ, 13 сая нь БНХАУ-аас байгаа юм.<sup>4</sup>

Харин монголчууд дотроо Монгол шиг хүйтэн, алс газар хэн ирэх вэ? гэх нь бий. Тэгвэл цаг агаар, газар зүйн байршлын хувьд хамгийн ойролцоо Өвөр Монгол гэхэд 2020 онд манай зорилтоос 135 дахин их буюу 135 сая жуулчин хүлээн авна гэсэн том зорилттой бөгөөд үүнээс 35 сая жуулчныг гадны улсаас хүлээн авах зорилттой ажиллаж байгаа юм.

Зураг 4

Өвөр Монголын аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал



4. Ямар шийдвэр гаргах ёстой вэ?

Монголд аялал жуулчлалын салбар хөгжихөд чухам ямар асуудал саад болж буйг дараах байдлаар томъёолж болно.

Аялал жуулчлал нь бизнес, хувийн хэвшил, иргэдийн гарт ирдэг шууд орлого учраас сүүлийн жилүүдэд төр засаг энэ салбарт анхаарал тавин ажиллаж байгаа. 2018 онд УБ-Сөүл, УБ-Бээжин чиглэлийн агаарын тээврийн салбарт чөлөөт өрсөлдөөн бий болгох бодлогын баримтын бичигт УИХ өөрчлөлт оруулсан билээ.

<sup>4</sup> www.amadeus.com

Зураг 5

Монгол Улсын аялал жуулчлалын салбарт тулгарч буй асуудал



Тоо баримтаас үзэхэд, 2018 онд Монгол Улсад зочилсон нийт 529370 жуулчны 49.7 хувь нь агаарын тээврээр ирсэн бол 2019 онд нийт нислэгийн суудлын тоог 34.4 хувиар өсгөснөөр агаарын тээврээр ирэх жуулчдын тоо 56 хувиар өсөх боломж бүрдээд байна.

Зураг 6

Агаарын тээврийг нэмэгдүүлэх чиглэл, боломжууд

АГААРЫН ТЭЭВЭРЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, БОЛОМЖУУД



Чиглэл	2018	2019 *	2020 *
Сүх	381,339	554,128 (53%) ↑	664,954 (20%) ↑
Зөвөн	270,550	345,972 (19%) ↑	373,889 (10%) ↑
Москва	74,216	129,384 (74%) ↑	142,333 (10%) ↑
Хан Кои	69,937	84,009 (20%) ↑	126,886 (50%) ↑
Токио	69,726	69,402 (-1%) ↓	78,942 (10%) ↑
Бусад	64,860	67,762 (5%) ↑	63,871 (10%) ↓
Улаанбаатар	42,058	47,898 (14%) ↑	112,378 (135%) ↑
Берлин	23,277	25,272 (9%) ↑	27,369 (10%) ↑
Дэвин	18,838	20,642 (9%) ↑	22,757 (10%) ↑
Орле	18,880	17,287 (9%) ↓	19,076 (10%) ↑
Манила	13,829	14,809 (9%) ↑	16,341 (10%) ↑
Бангкок	13,019	14,181 (9%) ↑	15,879 (10%) ↑
Хангз	11,828	12,654 (7%) ↑	13,919 (10%) ↑
Франкфурт	8,929	10,823 (9%) ↑	11,905 (10%) ↑
Улаан-Уд	4,972	5,418 (9%) ↑	5,961 (10%) ↑
Вул	3,848	4,194 (9%) ↑	4,814 (10%) ↑
Хайла	2,989	3,238 (9%) ↑	3,660 (10%) ↑
Занкаг	20,046	21,620 (9%) ↑	24,623 (10%) ↑
Нурүлтан		15,000	22,500 (50%) ↑
Гуанжоу		10,000	15,000 (50%) ↑
Шанхай		5,000	7,500 (50%) ↑
Бусад чиглэл			160,000
Нийт суудлын тоо	1,020,891	1,372,000 (34.4%) ↑	1,770,000 (29%) ↑

2018

Монгол улсын хэмжээнд 2019 онд БНСУ-ын агаарын тээвэрлэгч ASIANA AIRLINES авиа компани логотип нислэг үйлдэж байсан.

2019

2019 онд БНСУ-ын агаарын тээвэрлэгч ASIANA AIRLINES авиа компани логотип нислэг үйлдэж байсан. Нийтдээ 34.4%-р нэмэгдэнэ.

2020

2020 онд нийт суудлын тоог 29% нэмэгдүүлэхийн тулд TURKISH AIRLINES авиа компанийн нислэгийн давтамжийг тун өнгөцөөр 7 хэмэгт 7 удаа нэмжээ. 70,000 суудал нэмэгдэнэ.

Turkish Airlines: Зөвхөн суудлын боломжуугаас шалтгаалан жилдээ Монгол улс руу чөлөөтэн 100,000 зорчигчийн суудлын хүсэлтийг цувалдаг.

Эх сурвалж: Turkish Airlines

Зөвхөн агаар бол зорчигчийн үргэлж нэгтэй болжээ. Москва, Ханг Кои, Истанбул чиглэлүүдэд өрсөлдөгч бий болгож, тээвэрлэгчийн тоог энэхүү замар нислэгийн тоог нэмж, БНМАУ-аас дараагийн тээвэрлэгчийг оруула.

Дараагийн алхам бол аялагчдын визний асуудлыг шийдэх. Тунд, шатаах ивд, групп аялагчдыг илгүүг нэвтрүүлэх, хөл дээр ивд олгох гэх мэт.

Одоо тус салбарт бодлогын ямар өөрчлөлт шаардлагатай байгааг Зураг 7-д үзүүлье.

Зураг 7

### Шийдвэрлэх арга зам



Агаарын тээврийн салбарт чөлөөт өрсөлдөөнийг дэмжин, Монгол Улс руу ирэх нислэгийн тоог нэмснээр жуулчдын тоо, салбарын орлого тус тус хоёр дахин өсөх боломжтой юм.

Жуулчны виз олгох үйл ажиллагааг хялбарчлан цахим хэлбэрт шилжүүлж, нисэх буудалд шууд олгодог болох нь мөн л ашигтай. НҮБ-ын харьяа Дэлхийн аялал жуулчлалын газрын судалгаагаар тухайн улс орон жуулчдын визийг чөлөөлөх, эсвэл шууд хил дээр олгодог болсноор жуулчдын тоог хамгийн багадаа 30 хувиар нэмэгдүүлж чаддаг байна.<sup>5</sup>

Түүнчлэн дотоодын аялал жуулчлалын дэд бүтцийг сайжруулан, аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулдаг компанийг дэмжиж, тэдний бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартыг дээшлүүлэн, дэлхий дахинд сурталчлах хэрэгтэй.

Дүгнэж хэлэхэд, нэг сая жуулчин хүлээн авахын тулд төр, хувийн хэвшлийн байгууллагын аль алиных нь манлайлал, хүчин чармайлт, хамтын ажиллагаа чухал шаардлагатай.

<sup>5</sup> <http://www2.unwto.org>